



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/22

Ханх сум

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/81  
тоот захирамжийн хэрэгжилтийг хангуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/30 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/81 тоот “Мөсөн замаар тээврийн хэрэгслээр зорчихыг хориглох тухай” захирамж хангалттай хэрэгжихгүй байна. Иймд иргэд, тээвэрчид 2024 оны 04 дүгээр сарын сүүлийн өдрүүдэд цаг агаар огцом дулаарч Хөвсгөл нуурын мөс хайлж, мөсөн замд осол гарах эрсдэлтэй тул болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөсөн замаар авто тээврийн хэрэгслээр зорчихгүй, хөдөлгөөн үйлдэхгүй байх, аюулгүй байдлыг хангаж ажилласугай.

2.Хүн тээвэрлэлт эрхэлдэг аж ахуй нэгж, жолооч нарыг гол мөрөн, нуур дээгүүр тээвэрлэлт хийх үйлдлийг хориглож анхааруулах санамж бичиг тараан гарын үсэг зуруулахыг Цагдаагийн хэсэгт үүрэг болгосугай.

3.Сумын нийт ард иргэд, албан байгууллагад хориглосон шийдвэрийг давтамжтай сурталчлах, нуурын мөсөн дээр орох газруудад тэмдэг тэмдэглэгээ хийж байрлуулах ажлыг зохион байгуулахыг УТХГ-ын улсын байцаагч, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль хамгаалагч, Цагдаагийн хэсэг, багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч бөгөөд Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Б.Баттүвшин)-д даалгасугай.

ДАРГА

Л. ДАВААБАЯР

